



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 21/33

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэрэл суултын системийн сэлбэг нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны  
дарга: Х.Баттулга

Холбоо, навигаци, ажиглалтын албаны ерөнхий  
инженер

Нарийн бичгийн  
дарга: Ч.Ганзориг

Худалдан авах ажиллагааны тасгийн  
мэргэжилтэн

Гишүүд:  
Ж.Батбэх

Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холимог  
тэжээл, цахилгааны хэсгийн дарга

Ч.Бат-Оргил

Иргэний нисэхийн залуучуудын холбооны  
гишүүн

А.Энхцэцэг

“Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл” Төрийн бус  
байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн

2. Нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Х.Баттулга)-нд үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендер нээхэд Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үссэн тухай мэдэгдлийг гаргуулан Хуулийн хэлтэст хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ч.Ганзориг)-д даалгасугай.

ДАРГА П.МӨНХЖАРГАЛ

9020051071.№.6577539